



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 4/89

Улаанбаатар хот

В вируст гепатитын эсрэг вакцинаар
дархлаажуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасныг тус тус ТУШААХ нь:

1. Эмч, эмнэлгийн ажилчид болон сайн дурын үндсэн дээр 18-аас дээш насны иргэнийг тархвар судлалын заалтаар В вируст гепатитын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
2. В вируст гепатитын эсрэг вакцины хуваарийг нэгдүгээр, вакциныг хэрэглэх зааврыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Дархлаажуулалтын хамралт, зарцуулалтын мэдээг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дүгээр тушаалын дагуу сарын дархлаажуулалтын мэдээтэй хамт сар бүр Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн Дархлаажуулалтын албанд ирүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд)-т үүрэг болгосугай.

САЙД



С. ЭНХБОЛД

141220439

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/29 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

В вирус гепатитын эсрэг вакцин, тариурын хуваарь

	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Хамрагдах хүний тоо	Шаардлагатай вакцин 2 хүн тунгаар	10 хүн тунгаар савлагдсан вакцин	1 хүн тунгаар савлагдсан вакцин	Нийт олгох вакцин	Тариур /1 мл/
1	Архангай ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
2	Баян-Өлгий ЭМГ	2,000	4,000	2,500	1,500	4,000	4,000
3	Баянхонгор ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
4	Булган ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
5	Говь-Алтай ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
6	Говьсүмбэр ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
7	Дархан-Уул ЭМГ	2,000	4,000	2,500	1,500	4,000	4,000
8	Дорноговь ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
9	Дорнод ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
10	Дундговь ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
11	Завхан ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
12	Өвөрхангай ЭМГ	2,000	4,000	2,500	1,500	4,000	4,000
13	Өмнөговь ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
14	Сүхбаатар ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
15	Сэлэнгэ ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
16	Орхон ЭМГ	2,000	4,000	2,500	1,500	4,000	4,000
17	Төв ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
18	Увс ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
19	Ховд ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
20	Хөвсгөл ЭМГ	2,000	4,000	2,500	1,500	4,000	4,000
21	Хэнтий ЭМГ	1,600	3,200	2,500	700	3,200	3,200
22	Сүхбаатар ЭМТ	2,000	4,000	2,500	1,500	4,000	4,000
23	Чингэлтэй ЭМТ	2,000	4,000	2,500	1,500	4,000	4,000

24	Хан-Уул ЭМТ	2,000	4,000	2,500	1,500	4,000	4,000
25	Баянзүрх ЭМТ	2,200	4,400	2,500	1,900	4,400	4,400
26	Баянгол ЭМТ	2,000	4,000	2,500	1,500	4,000	4,000
27	Сонгинохайрхан ЭМТ	2,200	4,400	2,500	1,900	4,400	4,400
28	Багануур ЭМТ	1,000	2,000	1,500	500	2,000	2,000
29	Налайх ЭМТ	1,000	2,000	1,500	500	2,000	2,000
30	Багахангай ЭМТ	500	1,000	500	500	1,000	1,000
31	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	100	200	100	100	200	200
32	Амгалан амаржих газар	100	200	100	100	200	200
33	Хүрээ амаржих газар	100	200	100	100	200	200
34	Өргөө амаржих газар	100	200	100	100	200	200
35	Халдварт өвчин судлалын үндэсний төв	100	200	100	100	200	200
36	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	100	200	100	100	200	200
37	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	100	200	100	100	200	200
38	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	100	200	100	100	200	200
39	Улсын гуравдугаар төв эмнэлэг	100	200	100	100	200	200
40	Гэмтэл согог судлалын үндэсний төв	100	200	100	100	200	200
41	Хавдар судлалын үндэсний төв	100	200	100	100	200	200
42	Арьсны өвчин судлалын үндэсний төв	100	200	100	100	200	200
43	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	100	200	100	100	200	200
44	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	100	200	100	100	200	200
45	Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-2	100	200	100	100	200	200
	Нийт	52,000	104,000	72,500	31,500	104,000	104,000

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 489 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

В ВИРУСТ ГЕПАТИТЫН ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Энэ вакцин нь В вирусийн гадаргуугийн цэвэршүүлсэн антигенийг агуулдаг. Уг антигенийг *Hansenula polymorpha* хэмээх мөөгний эсэд генийн инженерийн аргаар В гепатитын гадаргуугийн антигений генийг таниулсны үндсэн дээр гаргаж авсан. ДЭМБ-ын шаардлагад нийцүүлсэн химийн аргаар гарган авсан хүн болон амьтны ямар нэг хольцгүй вакцин болно.

Найрлага:

Насанд хүрэгчдэд 1мл:

- 20 мкг гепатит В-ийн ялгасан цэвэр эсрэгтөрөгч
- 0.50 мг-0,80 мг хэмжээний хөнгөнцагааны гидроксид (Al+++)-д шингээсэн
- Тиомерсал 0,005%
- 1мл-ээр булчинд тарина

Тарих тун:

Насанд хүрэгчдийн тун: 20-оос дээш насныханд 1мл (20мкг)-ийг булчинд тарина.
Насанд хүрэгчдийг 3 тунгаар дархлаажуулах бөгөөд эхний тун тарьсан өдрөөс 1 сарын дараа 2 дахь тунгаар, 6 сарын дараа 3 дахь тунгаар дархлаажуулна.

Нэмэгдүүлсэн тун:

Нэмэгдүүлсэн тунг зөвхөн халдварын эрсдэл өндөр бүс нутагт байгаа дархлааны эсрэгбиеийн титр (10 ед/л)-ээс багассан, дархлаа хомсдол бүхий ХДХВ/ДОХ-ийн халдвартай хүмүүс болон цус шүүлгэж буй хүмүүст зөвлөнө.

Хэрэглэх заалт:

Вакциныг вирус гепатитын В хэв шинжийн халдварт өртөх эрсдлийн үед халдвар авахаас сэргийлж идэвхитэй дархлаажуулалтад хэрэглэнэ. Дархлаажуулалтаар В вирус гепатитын халдварт өвчнөөр өвчлөхөөс урьдчилан сэргийлж удаан хугацааны дархлаа тогтохоос гадна, архаг хэлбэрийн гепатит В болон үүнээс шалтгаалах элэгний цирроз, элэгний анхдагч өмөнгөөр өвчлөхөөс сэргийлнэ.

В вирус гепатитын халдварын тархалт багатай бүс нутагт неонатал/нярай болон өсвөр насныханд дархлаажуулалтыг дараах заалтаар хийнэ:

- Эмнэлгийн мэргэжилтний зөвлөмжөөр
- Ойрын хугацаанд цус цусан бүтээгдэхүүн хэрэглэсэн
- Их дээд сургуулийн ажилтан болон оюутнууд
- Бэлгийн онцлогоос хамаарсан эрсдэл бүхий хүмүүс
- Дур мэдэн тарилга хэрэглэгч
- В вирус гепатитын халдварын өндөр идэвхитэй улс орон руу явж буй хүмүүс
- Халдвар тээгч эхээс төрсөн нярайд
- Халдварын өндөр идэвхитэй бүс нутгаас ирсэн хүн
- Бусад: халдварт өвчний эрсдэл бүхий цэрэг, цагдаагийн ажилтан, гал унтраах болон онцой байдлын ажилтнууд
- Архаг хэлбэрийн гепатит В хэв шинжийн вирусийн хурц болон архаг хэлбэрийн өвчтэй хүнтэй хамт амьдардаг гэр бүлийн хүмүүс.

В вирус гепатитын халдварын тархалт дунд болон өндөр тархалттай газар нутагт амьдарч буй нярай, бага насны хүүхэд, өсвөр насныхан болон залууст өвчний тархалтыг зогсоохын тулд дархлаажуулалтыг заавал хийх хэрэгтэй.

Вакциныг бусад вакцинтай нэг дор хийж болох боловч тарилгыг нөгөө гарын булчинд хийнэ. Гэхдээ бусад вакциныг уусмалтай хольж болохгүй.

Эсрэг заалт:

В вируст гепатитын вакциныг өөр ямар нэг вакцинд харшилтай хүнд хийхийг хориглоно. Мөн өмнө нь В вируст гепатитын вакцины тунг авах үед урвал хүндрэл өгч байсан хүмүүст хийхийг хориглоно.

Урьдчилан сэргийлэлт ба анхааруулга:

В вируст гепатитын халдвар аваад удсан бол далд хэлбэрт орж улмаар дархлаажуулалтын явцад хүндрэл илэрч болно. В вируст гепатитын халдвараар өвчилсөн тохиолдолд вакцин нөлөөлөхгүй болохыг анхаарна уу.

Вакцин нь гепатитийн бусад хэв шинж болон элэгний бусад төрлийн үрэвсэлт өвчнүүдээс урьдчилан сэргийлэхгүй. 40-с дээш насны хүмүүст дархлаа тогтох нь бага байдаг.

Цус шүүлгэдэг өвчтөн болон дархлаа султай хүмүүст вакцин тарьсны дараа хангалттай титр бүхий эсрэгбие үүсэхгүй байж болно.

Бусад вакцинтай адил ямар нэгэн харшлын урвал үүсэхээс сэргийлж яаралтай тусламжийн хэрэгслийг бэлэн байлгах.

В вируст гепатитын вакциныг өгзөгний булчин болон арьсан дотор тарихгүй.

Урвал хүндрэл:

Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл эхний хэдэн өдөр илрэх боловч шинж тэмдэг багатай байдаг. Ихэвчлэн хөнгөн хэлбэрээр хөндүүрлэх, улайх, тавгүйтэх, халуурах, ядрах, улаан бурхан болон томуу төст хам шинжээр илэрдэг.

Ховор тохиолдолд ерөнхий хордлогын шинж тэмдэг болох дотор муухайрах, бөөлжих, суулгах, гэдэс өвдөх, эвгүй зүйл амтагдах, үеэр өвдөх, булчингаар өвдөх, тууралт, загатнах болон чонон хөрвөсийн шинжүүд илэрнэ.

Арга зүй:

В вируст гепатитын вакциныг насанд хүрэгчдэд бугалганы булчинд тарина. Цус гоожимхой, тромбоцитопенитэй хүнд вакциныг арьсан дор хийж болно. Вакциныг хэрэглэхийн өмнө сайтар сэгсрэх хэрэгтэй. Тарилга тус бүр шинэ, ариун зүү тариур хэрэглэнэ. ДЭМБ-ын зөвлөмжөөр олон тунт вакциныг задалсан бол 7 хоногийн хугацаанд +2-+8 хэмд хадгалж, хэрэглэж дуусгана.

Дархлал хомсрол:

Шинж тэмдэг илрэлтэй болон илрэлгүй дархлал хомсдолын вирусийн ХДХВ/ДОХ халдвар авсан өвчтэй хүнийг товллолын дагуу В вируст гепатитын вакцинаар дархлаажуулна.

Хадгалалт:

В вируст гепатитын вакциныг +2-+8 хэмд хадгална. ХӨЛДӨӨЖ БОЛОХГҮЙ.

Хугацаа:

Үйлдвэрлэснээс хойш 36 сар

Савалгаа:

1 флаконд 1 мл – 1 хүн тун /насанд хүрэгчдэд /
1 флаконд 10 мл-10 хүн тун /насанд хүрэгчдэд/

Вакцины шошгийн монитор:

Вакцины шошгийн мониторын дундах дөрвөлжин гаднах дугуйгаас цагаан, вакцины хадгалах хугацаа дуусаагүй тохиолдолд вакциныг хэрэглэж болно. Харин уг дөрвөлжин гаднах дугуйтай ижил юмуу түүнээс илүү бараан болсон тохиолдолд вакциныг хэрэглэж болохгүй. Энэ нь вакцин дулааны нөлөөлөлд өртсөнийг харуулдаг.

Үйлдвэрлэгч:

SERUM INSTITUTE OF INDIA PVT.LTD.